



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 27 өдөр

Дугаар А/81

Халбан

**Монгол Улсын Их Хурлын сонгуулийн  
тухай хуулийн хэрэгжилтийг хангах талаар  
авах арга хэмжээний тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23-ын заалт, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1.1, 70.1.2, 70.1.3, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 22-р зүйлийн 22.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн санал авах (зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар болон санал авах байранд) хяналтын тооллого хийхтэй холбогдуулан сумын нутаг дэвсгэрт 2024 оны 06 дугаар сарын 27,28,29-ний өдрийг дуустал хугацаанд архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилэхийг, хориглосугай.
2. Согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгж, байгууллага, иргэдэд үүрэг болгосугай.
3. Захирамжийг олон нийтэд сурталчилж, мэдээлэх, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын хэсгийн төлөөлөгч /Д.Нямдорж/-д даалгасугай.
4. Энэ захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг ЗДТГ-ын дарга /Б.Бямбажав/-т үүрэг болгосугай.

ДАРГА  Н.ЛНХБАЯР

